



БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Улаанбаатар хот 2022 он

“ХОНГОРЫН ОРД” ХХК

Улаанбаатар хот, ХАН УУЛ дүүрэг, 15-р хороо,
Жаргалан хотхон 4 байр 9 тоот
Утас:99093846, 99007180

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЧЛАЛЫН ГАЗАРТ**

2023 оны 03 сарын 10-нд

№23/06

Улаанбаатар хот

Тайлан хүргүүлэх тухай:

Манай компани нь Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт **MV-016981** тоот тусгай зөвшөөрөлтэй, 11.97 га талбайтай Наран алтны шороон орд эзэмшдэг.

2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг БОАЖСайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний А/618 дугаар тушаалын хавсралт “ Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулан илгээж байна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  /С.БОЛОР/



СЭЛЭНГЭ АЙМГИЙН БАЯНГОЛ СУМЫН НУТАГТ
ХЭРЭГЖИЖ БУЙ “НАРАНГИЙН АМАНД БАЙРЛАХ АЛТНЫ
ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСӨЛ”-ИЙН
2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

ХЯНАСАН:

БОАЖЯ-НЫ ХБОБНУГ-ЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ: /

/(Ц.ЖАРГАЛНЭМЭХ)

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

“ХОНГОРЫН ОРД” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ: /

/(С.БОЛОР)

“ХОНГОРЫН ОРД” ХХК-ИЙН БО-НЫ МЭРГЭЖИЛТЭН: /

/А.ЭНХТУЯА)

АГУУЛГА

АГУУЛГА	0
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	2
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	3
НЭГ. ТУХАЙН ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА..	5
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл	8
1.2. Төслийн байршил.....	9
ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТАНИЛЦУУЛГА	11
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	13
3.1. Болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ	13
3.2. Төслийн гол сөрөг нөлөөллийн үнэлгээ	14
ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	15
ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ	16
5.1. Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт.....	16
5.2. Ургамлын аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт.....	18
5.3. Усан орчин.....	19
Усны чанар, нөөц, бохирдлын мониторинг.....	21
5.3.1. Судалгааны арга зүй.....	21
5.3.2. Усны чанарын мониторингийн үр дүн	21
5.4. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт.....	23
Хөрсний чанар, бохирдлын мониторинг	24
5.4.1. Лабораторийн задлан шинжилгээ.....	24
5.4.2. Хөрсний бохирдлын түвшин.....	24
5.5. Агаар орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт	25
Агаарын чанар, бохирдлын мониторинг	27
5.5.1. Агаарын судалгааны арга зүй.....	27
5.5.2. Агаар бохирдуулах бодисуудын тодорхойлолт	27
5.5.3. Агаарын чанарын төлөв байдал.....	30
5.5.4. Азотын давхар исэл /NO ₂ /-ийн агууламж	30
5.5.5. Хүхэрлэг хий /SO ₂ /-ын агууламж:.....	31

5.5.6. Том ширхэглэгт тоосонцор /PM10/-ын агууламж	31
ЗУРГАА. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ	33
ДОЛОО. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ, ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ	34
НАЙМ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ.....	41
ЕС. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ.....	41
АРАВ. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ	42
АРВАН НЭГ. ХОГ ХАЯГДАЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ	44
АРВАН ХОЁР. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ	49
АРВАН ГУРАВ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ.....	51
АРВАН ДӨРӨВ. ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ.....	59
АРВАН ТАВ. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРА ХЭМЖЭЭ.....	61

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн газарзүйн солбицол.....	9
Хүснэгт 2. Болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ.....	13
Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт (амьтаны аймаг).....	16
Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт (ургамлын аймаг	18
Хүснэгт 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт /усны менежмент/	19
Хүснэгт 6. Усны шинжилгээний аргачлал.....	21
Хүснэгт 6. Гадаргын усны мониторингийн цэгүүдийн координат.....	21
Хүснэгт 7. Усны шинжилгээний дүн.....	22
Хүснэгт 8. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт /газрын менежмент/	23
Хүснэгт 9. Хөрсний үзүүлэлт /хүнд металл/.....	24
Хүснэгт 10. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт /агаарын менежмент/	25
Хүснэгт 11. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилт.....	33

Хүснэгт 12. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	34
Хүснэгт 13. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	41
Хүснэгт 14. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт	41
Хүснэгт 15. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт	42
Хүснэгт 16. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт	44
Хүснэгт 17. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилт	49
Хүснэгт 18. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт	51
Хүснэгт 19. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний хэрэгжилт	59

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг №1. Техникийн нөхөн сэргээлт хийсэн тодорхойлолт (2020оны В-1 блок).....	5
Зураг №2. В-1 блокийн кариерийн зураг	6
Зураг №3. В-1 блокийн Техникийн нөхөн сэргээлтийн дунд үе	6
Зураг №4. В-1 блокийн Техникийн нөхөн сэргээлтийн эцсийн үе шат	7
Зураг №5. В-1 блокийн Техникийн нөхөн сэргээлт дуусаж, шимт хөрсөөр хучсан байдал.....	7
Зураг №6. Төсөл хэрэгжих газрын ерөнхий байршил.....	10
Зураг №7. ХАБЭА болон ББО-ны сэдэвт сургалтын үйл явц	17
Зураг №8. Зам талбайн усалгаа хийж буй байдал.....	29
Зураг №9. Унд ахуйн хаягдал усыг саарал ус болгож зам талбай, ногоон байгууламжинд ашиглаж буй байдал	20
Зураг №10. Усалгаа хийж буй байдал.....	31
Зураг №11. Усалгаа хийж буй байдал.....	26
Зураг №12. Агаар мандал дахь тоосонцорын харьцангуй агууламж.....	29
Зураг №13. Агаар дахь тоосонцорын ширхгийн хэмжээнээсээ хамааран хүний амьсгалын эрхтнүүдээр шүүгдэж хуримтлагдах хэмжээ	29
Зураг №14. Агаар дахь тоос хэмжигч багаж	360
Зураг №15. Азотын давхар исэлийн хэмжээ	31
Зураг №16. Хүхэрлэг хэмжээ.....	31
Зураг №17. Тоосонцорын хэмжээ.....	32
Зураг №18. Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай	35
Зураг №19. Нөхөн сэргээлт хийсэн талбай.....	36
Зураг №20. Нөхөн сэргээлт хийсэн талбайн солбицол	37
Зураг №21. Тэрбум мод үндэсний хөдөлгөөн	38
Зураг №22. Тэрбум мод үндэсний хөдөлгөөн	38

Зураг №23. Тэрбум мод үндэсний хөдөлгөөн.....	39
Зураг №24. Модны суулгацын төлбөр шилжүллсэн баримт.....	40
Зураг №25. Ажилчдад хөдөлмөр хамгааллын сургалт орж буй байдал.....	44
Зураг №26. Бүх нийтийн цэвэрлэгээ.....	47
Зураг №27. Бүх нийтийн цэвэрлэгээ.....	47
Зураг №28. Бохирын цооног.....	48
Зураг №29. Энгийн хог хаягдал ангилан ялгах сав.....	48
Зураг №30. Хаягдал тос түр хадгалах сав.....	49
Зураг №31. Баян, манартын голын гүүрний ажил.....	53
Зураг №32. Баян, манартын голын гүүрний ажил.....	53
Зураг №33. Баян, манартын голын гүүрний ажил.....	54
Зураг №34. Ахмадын сувилалын засварын ажил.....	55
Зураг №35. Ахмалын сувилалын засварын ажил.....	56
Зураг №36. Ахмадын сувилалын засварын ажил.....	57
Зураг №37. Засварын ажил гүйцэтгэсэн тухай тодорхойлолт.....	58
Зураг №38. Сумын иргэдэд БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнаж байгаа.....	60

НЭГ. ТУХАЙН ОНЫ УУЛЫН АЖЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших Нарангийн алтны шороон орд нь 2022 онд хөрс хуулалтын ажил хийгдээгүй бөгөөд 2020 оны нөөцөлсөн В-1 блокийн үлдэгдэл 1.57 мян.м³ элсийг дахин угаан баяжуулж, 1.94 кг алт Монгол банкинд тушаасан.

2020 онд ашиглалтын үйл ажиллагааг В-1 нөөцийн блок бүтнээр эхний ашиглалтын блок үүсгэж эхлүүлсэн. Олборлолтын эхний шатанд 0.4-0.8м зузаан шимт хөрсийг хуулж 360м³ эзэлхүүнтэй шимт хөрсний гадаад овоолго үүсгэсэн. Үүний дараагаар, 5.2-12.4м зузаан цайвар шаргал өнгийн, ховроор хайрга агуулсан шаварлаг элс, элсэнцэрээс тогтсон хөрсний үеийг хуулж 17.0мян.м³ эзэлхүүнтэй дотоод овоолго байгуулсан. Энэ үеийн доороос илэрсэн дунджаар 2м зузаан бүхий шижирмэг алт агуулсан голын хайрга, хайрганцарын үеийг ул чулуулагын 0.5м уулын цултай нийлүүлэн 3636.48.м³ баяжмалын овоолго үүсгэн, 2.06 мян.м³ элсийг угаан баяжуулж 1.51 кг алтыг Эрдэнэсийн санд тушаасан. 2020 онд 1.57 мян.м³ баяжмалын овоолго үлдсэн В-1 блокийн техникийн нөхөн сэргээлтийг хийж шимт хөрсөөр хучин орон нутагт хүлээлгэж өгөөд 2020 оны уулын ажил дуусгавар болсон.





Зураг №2. В-1 блокийн карьерийн зураг



Зураг №3. В-1 блокийн Техникийн нөхөн сэргээлтийн дунд үе



Зураг №4. В-1 блокийн Техникийн нөхөн сэргээлтийн эцсийн үе шат



Зураг №5. В-1 блокийн Техникийн нөхөн сэргээлт дуусаж, шимт хөрсөөр хучсан байдал

1.1. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.

- Төслийн нэр:*
- “Нарангийн аманд байрлах алтны шороон ордыг ашиглах” төсөл
- Төсөл хэрэгжүүлэх аж ахуй нэгж, байгууллагын нар:*
- “Хонгорын орд” ХХК
Улсын бүртгэлийн дугаар: 9011107085
Регистрийн дугаар: 2577453
- Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:*
- УБ хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, 2-р давхар, Утас: 99093846
- Төсөл хэрэгжих үе шат:*
- MV-016981 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайг 2 жилийн хугацаанд ашиглана.
- Төслийн зорилго, цар хүрээ:*
- Нарангийн алтны шороон ордын хайгуулын 76-77-р шугам, Жалга-II, Жалга-III нэртэй MV-016981 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий АМХЭГ-ын кадастрын хэлтсээс 2001.04.18-нд 12.21 га талбайг “Хонгорын орд” ХХК-д олгосон байдаг бөгөөд сүүлд 2016 онд хэсэгчлэн буцаалт хийж 11.97 га талбайг хамрах болсон.
 - Тухайн ордын нөхцөлд тохирох ашиглалтын системийг сонгон хэрэгжүүлж, эдийн засгийн эргэлтэнд оруулах, ажлын байр нэмэгдүүлэх, улс орон нутгийн төсөдв хувь нэмрээ оруулах.

1.2. ТӨСЛИЙН БАЙРШИЛ.


Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших MV-016981 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Нарангийн алтны шороон ордын талбай нь Улаанбаатар хотоос 200 км-т, Шарын гол нүүрсний уурхайгаас зүүн урагш 25 км-т, Баруунхараагаас 60км зайд, дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн районд оршдог.

Талбайн хэмжээ: 11.97га

Талбайн байр зүйн зургийн нэрэлбэр: М-48-125, М-48-126

Хүснэгт №1. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн газарзүйн солбицол

№	Газарзүйн солбицол						Тэгш өнцөгтийн солбицол	
	ӨРГӨРӨГ			УРТРАГ			Х	Ү
1.	49 ⁰	6'	14.93"	106 ⁰	29'	45.19"	5,384,174.67	619,978.94
2.	49 ⁰	6'	1.92"	106 ⁰	29'	45.19"	5,384,123.18	620,041.30
3.	49 ⁰	6'	1.92"	106 ⁰	29'	32.15"	5,384,072.14	620,052.83
4.	49 ⁰	6'	3.01"	106 ⁰	29'	32"	5,384,009.36	620,092.49
5.	49 ⁰	6'	3.06"	106 ⁰	29'	31.96"	5,383,960.35	620,155.41
6.	49 ⁰	6'	3.28"	106 ⁰	29'	31.79"	5,383,955.27	619,931.57
7.	49 ⁰	6'	3.33"	106 ⁰	29'	31.76"	5,384,079.21	619,659.10
8.	49 ⁰	6'	3.56"	106 ⁰	29'	31.58"	5,384,132.42	619,357.20
9.	49 ⁰	6'	3.58"	106 ⁰	29'	31.55"	5,384,162.16	619,361.28
10.	49 ⁰	6'	3.6"	106 ⁰	29'	31.54"	5,384,168.58	619,416.47
11.	49 ⁰	6'	3.83"	106 ⁰	29'	31.33"	5,384,151.65	619,535.86
12.	49 ⁰	6'	3.88"	106 ⁰	29'	31.29"	5,384,134.79	619,643.78
13.	49 ⁰	6'	4.97"	106 ⁰	29'	30.33"	5,384,134.76	619,700.53
14.	49 ⁰	6'	4.97"	106 ⁰	29'	30.18"	5,384,151.55	619,734.60
15.	49 ⁰	6'	14.93"	106 ⁰	29'	30.18"	5,384,185.89	619,751.49



Зураг № 6. Төсөл хэрэгжих газрын ерөнхий байршил

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТАНИЛЦУУЛГА

Сэлэнгэ аймгийн Баянгол сум нь 1931 онд Богдхан уулын аймгийн Баатарвангийн хошууны Хөлий-Баян-Уул сумын суурин дээр Түнхийн аманд Хараа голын хөндийд байгуулагдан 1954 онд Мандах нэгдэл нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байгаад 1968 онд Баруунхараа САА болон өргөжин 1992 онд шинэ Үндсэн хуулиар Баянгол сум болон цэцэглэн хөгжиж байна. Тус сум нь 197.6 мянган га газар нутагтай, засаг захиргааны анхан шатны нэгж 3 багтай, 5479 хүн амтай, 1590 өрхтэй, төр төсвийн 9 байгууллагатай, 123.4 мянган толгой малтай. Хүн амын тоогоор Сэлэнгэ аймгийн 17 сумаас эхнээсээ 4-д, газар нутгийн хэмжээгээр 10-д ордог хүн амын нягтрал ихтэй 35,9 хүн/га ногддог сум юм.

Баянгол сум нь Гринвичийн Зүүн уртрагаас 106004,56, хойд өргөрөгийн 48054,52-д оршдог. Монгол орны Хангай Хэнтийн уулархаг их мужийн Хэнтий нурууны дэд мужийн Хэнтийн баруун захын бэсрэг уулсын тойрогт хамаарагдана. Сумын нутаг дэвсгэр нь уул, гүвээ толгод бүхий тал хээр буюу мал аж ахуй болон газар тариалан эрхлэхэд тохиромжтой.

Мал сүрэг

Сумын хэмжээгээр нийт цэвэр үүлдэр, эрлийз, нутгийн шилмэл омгийн 73883 толгой мал тоологдсон нь нийт малын 59,9 хувь байна. Сумын хэмжээнд 399 малчин өрх, 479 малтай өрх байгаа нь нийлээд сумын нийт өрхийн 55,2 хувийг эзэлж байна.

Мал, сүргийн бүтэцСумын хэмжээнд 123465 толгой малтайгаас адуу 6496 толгой, үхэр 13862 толгой хонь 63114 толгой, ямаа 39993 толгой байна.

Зам харилцаа

Сумын газар нутаг дээгүүр ОХУ-ыг Нийслэлтэй холбосон улсын чанартай 35.6 км авто зам дайран өнгөрдөг. Багууд хоорондоо шороон замаар холбогддог.

Усан хангамж

Сумын төвд цэвэр усны эх үүсвэрийн гүний худаг 2, 250 м³ багтаамжтай 1 усан сан, цагт 25 м³ хүчин чадалтай 1 насос станц, цэвэр усны 1.75 км урт шугам хоолой, 1,75 км дулааны шугам байгаа ба худгаас усан сангаар дамжуулан 2 насосоор татан шугам хоолойгоор шахаж ус түгээж байна. Төвлөрсөн ус хангамжийн системд 170 өрх, 18 аж ахуйн нэгж холбогдож цэвэр усаар хангагдаж байна.

Усан сан, Төвлөрсөн усан хангамж 250 м³ хүчин чадалтай 2012 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар усан хангамжийг шинэчилсэн. Үүнд: даралтат цамхаг ашиглаж байсныг болиулж Инвектор төхөөрөмжит насос суурилуулан байнгын даралтаар сумын усан хангамжийг түгээх болсон.

Дулаан хангамж

Сумын төвд халаалтын төв 1, 1 мегаваттын 2 зуух, 54-ын 2 тогоо нийт 3 мегаваттын хүчин чадлаар ажиллаж байна. Сумын инженерийн шугам сүлжээ 1968 онд ашиглалтанд орсон цагаас хойш засвар үйлчилгээ хийгээгүй учраас шинэчлэх

шаардлагатай. Сумын орон сууцнууд нь хэрэглээний халуун усны шугамгүй байгаагаас сумын хэмжээнд дулаан хангамжийг өргөтгөх зайлшгүй шаардлага гарсаар байна. Уурын зуухны барилга хуучирч муудсан тул барилгад их засвар хийх шаардлагатай байна.

Боловсрол

Ерөнхий боловсролын 12 жилийн сургууль Хараа багт байршилтай 640 хүүхдийн хүчин чадалтай, одоогоор 869 хүүхэд суралцаж байна. 72 багш, ажиллагсадтай. 1968 онд ЗХУ-ын тусламжтайгаар 192 хүүхдийн суудалтай хичээлийн байр, 80 хүүхдийн дотуур байр, 120 хүүхдийн суудалтай цайны газар бүхий иж бүрэн барилга, тоног төхөөрөмжийг хүлээн авсан байна. 1987, 1992 онуудад сургуулийн барилгад 2 удаа өргөтгөл хийгдэж, 1991-1992 оны хичээлийн жилээс эхлэн 640 хүүхдийн суудалтай болон өргөжсөн.

Эрүүл мэнд

Суманд улсын төсвийн 12 ортой 1 эмнэлэг, 2 эмийн сан үйл ажиллагаа явуулж, 3 их эмч, 12 эмнэлгийн тусгай мэргэжилтнүүд ажиллаж байна. 2012 онд нийт 108 хүүхэд мэндэлж, 0-1 насны хүүхдийн эндэгдэл, эхийн эндэгдэл байхгүй байна. Нийт өвчлөлийг авч үзвэл халдварт бус өвчлөл 719, осол гэмтэл 115, халдварт өвчлөлийн 42 тохиолдол гарсан байна.

Соёл урлаг, спорт

Соёлын төвийн чулуун бетонон барилга нь соёлын үйл ажиллагаа тогтмол явуулж байна. Тус барилгад соёл урлагийн арга хэмжээ, олон төрлийн уралдаан тэмцээн, 3 төрлийн дугуйлан, номын сангийн үйлчилгээ, орон нутаг судлах танхим, зэрэг соёл урлагийн бүх үйл ажиллагаа явагддаг. Жилдээ 12000 гаруй хүнд соёл урлагийн үйлчилгээг хүргэж байна. Спорт цогцолбор нь 1988 ашиглалтанд орсон. 3 орон тоотой, 9 төрлийн спортын секц дугуйлангууд хичээллэдэг. 2012 онд бялдаржуулах клуб нээгдэн аж ахуйн нэгж байгууллага, иргэд, суралцагчид, оюутнуудад хуваарийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байна. Жилдээ 9000 гаруй хүнд үйлчлэн спортын 25-30 төрлийн уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулдаг.

Тус сум Ахуйн үйлчилгээний нэгдсэн төв байхгүй, худалдаа үйлчилгээний 45 цэг, үсчин гоо сайхны 2, гутал засварын 1, оёдлын 2, нийтийн халуун усны 3 цэг салангид үйл ажиллагаа эрхэлж байна.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг төслийн 2022 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн боловсруулав.

3.1. Болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ

Тухайн төслийн болзошгүй нөлөөллийн үнэлгээг хийхдээ “Магадлан жагсаах буюу хяналтын хуудасны арга” (Checklist)-ыг хэрэглэв. Энэ арга нь байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийн төрлийг жагсаан тэдгээрийг төсөлтэй холбоотойгоор харьцуулан тодорхойлсон хүснэгт бүрдүүлэх арга юм.

Болзошгүй нөлөөлөлд хамрагдах байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийг байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт, байгалийн нөөц ашиглалт, байгаль орчны өөрчлөлт, нийгэм-эдийн засаг, бусад гэсэн 5-н үндсэн бүлэгт багцлан хувааж, магадлан жагсаах аргаар судлав. Нөлөөллийг “сөрөг”=(-), “эерэг”=(+), “нөлөөлөлгүй”=(0) гэсэн 3-н бүлэглэлээр үнэлж, эрчимжилтийг: “бага”, “дунд”, “хүчтэй” гэсэн 3-н зэргээр тогтоож, хэлбэр, хугацаа, чиглэлээр нь үнэлсэн.

Хүснэгт 2. Болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ

Байгаль орчны үзүүлэлт	Хэлбэр			Хугацаа			Нөлөө		Эрчим		
	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагда	Богино	Дунд	Урт	Буцах	Буцалтгүй	Бага	Дунд	Хүчтэй
Байгалийн экосистемийн өөрчлөлт											
Газрын доорх усны урсац, горим, чанар өөрчлөгдөх	-					-		-			-
Уурхайн ухаш, хөрсний овоолго, зам болон бусад барилга байгууламжаас ургамлын бүлгэмдэл, бүтцэд өөрчлөлт орох, талхлагдах	-					-		-			-
Уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас /хөрс хуулалт, олборлолт, овоолго, зам, барилга байгууламж/ хөрсөн бүрхэвч элэгдэх, эвдрэлд орох, дарагдах	-					-		-			-
Хөрс хуулалт, хүдэр олборлолтоос геологийн тогтоц өөрчлөгдөх	-					-		-			-
Хүн, машин техникийн хөдөлгөөн, газар шорооны ажилтай холбоотойгоор ойр орчимд нутагладаг ан амьтдын амьдрах орон зай өөрчлөгдөх	-				-			-			-
Бичил уур амьсгал өөрчлөгдөх		-		-				-		-	
Байгалийн нөөц ашиглалт											
Газрын нөөц баялаг	-				-			-			-
Газрын доорх усны нөөц	-				-					-	
Бэлчээрийн нөөц	-				-			-			-
Эрдэс түүхий эдийн нөөц	-				-			-	-		

Эрчим хүчний нөөц			-	-				-		
Байгаль орчны чанарын өөрчлөлт										
Газрын доорх ус бохирдох		-		-			-			-
Гадаргы усны бохирдол	Төслийн гадаргын урсацтай гол байхгүй.									
Агаар бохирдох	-			-			-		-	
Хөрс бохирдох	-			-			-			-
Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйлс										
Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх	-			-					-	
Ландшафтын хэлбэр өөрчлөгдөх	-			-					-	
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх		-		-				-	-	
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх	-			-				-	-	
Археологи, палентологийн олдворт нөлөөлөх	-			-				-	-	
Эдийн засаг, нийгмийн асуудал										
Татварын орлого нэмэгдэх	+			+						+
Орон нутгийн орлого нэмэгдэх	+			+						+
Ядуурлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх	+			+						+
Ажлын байр нэмэгдэх	+			+						+
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх	-	-		-						-
Нийт	20	5	1	3	17	4	4	8	3	8

Тайлбар: Сөрөг нөлөөлөл. Хүчтэй /-/ , Дунд /-/ , Бага /-/ , Нөлөөлөл байхгүй /0/, Эерэг нөлөөлөл /+/ гэсэн тэмдэглэлээр үзүүлэв.

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх шууд нөлөөлөл 20, шууд бус нөлөөлөл 4 байна. Нийт нөлөөллийн 7 нь бага эрчимтэй, 5 дунд эрчимтэй, 8 хүчтэй нөлөөлөлд хамрагдаж байна. Нийт нөлөөллийн 80.8% нь сөрөг, 19.2% нь эерэг нөлөөлөл байна. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нийт нөлөөлөл нь шууд, дунд хугацааны, дунд зэргийн нөлөөлөл байна.

3.2. Төслийн гол сөрөг нөлөөллийн үнэлгээ

Болзошгүй нөлөөллийн үр дүнгээр Нарангийн аманд байрлах алтны шороон ордын үйл ажиллагаа болон төслийн бүтээн байгуулалт, олборлолтын үед агаар, хөрс, ургамал, газрын доорх ус, амьтан зэрэгт сөрөг нөлөөтэй байна.

ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, БОННҮнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрх зүйн баримт бичиг юм.

Мөн төлөөлөгчид байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага, зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах арилгах талаар авах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах цаг хугацаа, хөрөнгө зардлыг бодитой тусгасан байх шаардлагатай.

Төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг тухайн төслийг хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага нь үйл ажиллагааныхаа зардалд багтаан төлөвлөж зарцуулах.

Иймд “ХОНГОРЫН ОРД” ХХК нь байгаль орчинд ээлтэй үйл ажилагаа явуулах зорилгын хүрээнд 2022 оны БОМТөлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах зорилготой.

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

5.1. Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт

Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт /амьтны аймаг/

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Төлөвлөгөөний хэрэгжилтэнд зарцуулсан хөрөнгийн хэмжээ, мян.төг	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
1	Ховор болон нэн ховор амьтад, тэдгээрийн нүүдэл хөдөлгөөний талаар, жолооч нарт төслийн талбайн дотор болон гадна анхаарал болгоомжтой зорчих талаар сургалт явуулах	“Хонгорын Орд” ХХК-ийн үндсэн болон гэрээт компанийн ажилчид	Дотоод төлөвлөлтөөр	Төслийн нийт ажилчдад байгаль орчин болоод ХАБЭА-н сургалтаар дамжуулан БО-той холбоотой бүхий л мэдээллийг тогтмол өгч ажилласан.
2	Төслийн үйл ажиллагааны талбай, дэд бүтцийн шугам дагуу үхсэн амьтны сэг зэмийг зайлуулах, булж устгах	Уурхайн талбай, дэд бүтцийн шугам дагуу	Дотоод төлөвлөлтөөр	Төслийн талбай орчим зэрлэг амьтан, мал зүй бусаар хорогдсон тохиолд аливаа халдварт өвчний тархалтаар сэргийлж шатаах, булж зайлуулах зэрэг арга хэмжээг зохион байгуулах төлөвлөгөөтэй ажилласан боловч 2022 онд дээрх тохиолдол гараагүй байна.
3	Цаг хүндэрсэн нөхцөлд зэрлэг амьтанд өвс, хужир тавьж өгөх биотехникийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Ойр орших ТХГ болон орон нутагтай тохиролцох	500.0	2022.12.25-нд 20 боодол өвсийг тарааж тавьсан. (Зураг №6)



Зураг №6. 80 боодол өвс тарааж тавьсан



Зураг №7. ХАБЭА болон БО-ны сэдэвт сургалтын үйл явц

5.2. Ургамлын аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт

Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт /ургамлын аймаг/

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Төлөвлөгөөний хэрэгжилтэнд зарцуулсан хөрөнгийн хэмжээ, мян.төг	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
1	Газар ашиглалтын урьдчилсан төлөвлөлт болон ГХЗ хүссэн талбайн ургамалжилтын судалгааны үндсэн дээр ургамалжилтын мэдээллийг ГМС-д бүртгэн, уурхайн лицензийн талбай дахь ургамлын тархалтын зураглалыг хийх	Төслийн үйл ажиллагааны талбайн хэмжээнд	Дотоод төлөвлөлтөөр	Уурхайн карьер тэлэх, шинээр газар хөндөх тохиолдолд шимт хөрсийг стандартын дагуу хуулж, тухайн газарт ургамалжилтын судалгаа хийх ажлыг зохион байгуулдаг. 2022 онд шинээр карьер нээгээгүй болно.

5.3. Усан орчин

Хүснэгт 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт /усны менежмент/

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Төлөвлөгөөний хэрэгжилтэнд зарцуулсан хөрөнгийн хэмжээ, мян.төг	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
1	Төслийн нийт усны хэрэгцээг багасгах, эргүүлэн ашиглах усны хэмжээг зорилтод төвшинд байлгах, нэмэлт боломжуудыг судлах, усны зохистой ашиглалтын талаар сургалт явуулах.	Үндсэн болон гэрээт компанийн ажилчид, болон зочид	Дотоод төлөвлөлтөөр	Унд ахуйн хэрэглээнээс гарсан саарал усыг зам талбай, ногоон байгууламжийн усалгаанд эргүүлэн ашиглаж төслийн нийт усны хэрэглээг багасгаж ажилласан. /зураг №8, 9/
2	Ундны усыг тогтмол хугацаанд шинжлүүлж байна.	Уурхайн талбай	500.0	2022 онд төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор 10 дугаар сард унд ахуйн худгаас усны дээж авч “Инженер Геодези” ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораторит шинжлүүлсэн. Усны дээжний үр дүнг тайлангийн ОХШХ -ийн усны хэсэгт дэлгэрэнгүй оруулсан бөгөөд тайлангийн хавсралт хэсэгт дээжний хариуг хавсаргав.



Зураг №8. Зам талбайн усалгаа хийж буй байдал

Зураг №9. Унд ахуйн хаягдал усыг саарал ус болгож зам талбай, ногоон байгууламжид ашиглаж буй байдал

Усны чанар, нөөц, бохирдлын мониторинг

5.3.1. Судалгааны арга зүй

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутаг дэвсгэрт орших “Хонгорын Орд” ХХК-ийн Нарангийн аманд байрлах алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн талбайн ойролцоох булгийн усны чанарыг тодорхойлох зорилгоор дээжлэлт хийж усны химийн ерөнхий үзүүлэлтүүдийг ШУА, Газарзүй Геоэкологийн хүрээлэнгийн усны шинжилгээний лабораторит шинжлүүлсэн болно. Усны шинжилгээний лаборатори нь биоген элементүүд болох аммони (NH₄), нитрит (NO₂), нитрат (NO₃), исэлдэх чанар (ПИЧ), гол ионууд болох сульфат (SO₄), төмөр (Fe), ерөнхий хатуулаг, кальци (Ca²⁺), магни (Mg²⁺) зэргийн агууламжийг тодорхойлдог ба усны шинжилгээ хийсэн аргачлалыг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 6. Усны шинжилгээний аргачлал

№	Шинжилсэн үзүүлэлтүүд	Шинжилгээний аргачлал
1	Ерөнхий хатуулаг	Комплексометрийн арга
2	Хлорид	Арганометрийн арга
3	Кальци	Комплексометрийн арга
4	Магни	Тооцооны арга
5	Сульфат	Турбидиметрийн арга
6	Төмөр	Колориметрийн арга
7	Аммони, нитрат, нитрит	Харааны колометрийн арга

Гадаргын усны шинжилгээний үр дүнг MNS 4586:1998 “Усан орчны чанарын үзүүлэлт, ерөнхий шаардлага” стандарттай харьцуулж дүгнэлт гаргалаа.

Тус судалгааны ажлын гадаргын усны цэгээс 1.5 литрийн багтаамжтай полиэтилен саванд усны дээжлэлт хийсэн. Дээж авахдаа саваа тухайн усаар зайлж дээжний савыг дээжээр бүрэн дүүргэж дээр нь агаар байх зайгүйгээр тагласан. Энэ нь тээвэрлэлтийн явцад сэгсрэгдэх, хийнүүдийн хоорондох харилцан үйлчлэлийг хязгаарлана. Тээвэрлэлтийн үед дээжийг харанхуй, сэрүүн газар хадгалсан болно.

Усны дээж авсан цэгийн байршлын координатыг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 6. Гадаргын усны мониторингийн цэгүүдийн координат

№	Дээжний төрөл, нэр	Солбицол	
		Уртраг	Өргөрөг
2022 оны 09 дүгээр сард авсан дээж			
1	Гүний худаг	49 ⁰ 06.028 ^{II}	106 ⁰ 29.53 ^{II}

5.3.2. Усны чанарын мониторингийн үр дүн

Байгаль орчны хяналт шинжилгээний ажлын хүрээнд Ханлаб ХХК-ний орчны шинжилгээний лабораторийн шинжилгээний дүнд анализ хийв.

Хүснэгт 7. Усны шинжилгээний дүн

Д/д	1	2	3
Лаб #			

Дээж #	Худаг	Гол	Шүүрлийн ус	Зөвшөөрөгдөх хэмжээ MNS 0900 : 2018	
Элемент нэгж	Мг/л	Мг-экв/л	Экв %		
1	K+	13.7	5.2	13.3	-
2	Na+	13.7	5.2	13.3	200
3	NH4+	0.0	0.0	0.0	
4	Ca2+	43.1	27.9	32.9	100
5	Mg2+	12.4	9.4	7.1	30
6	Нийлбэр катион	69.2	42.5	53.2	
7	Cl	5.7	2.8	2.8	350
8	SO4	18	14.0	20.0	500
9	NO2	0.0	0.0	0.0	1
10	NO3	8.0	1.0	0.0	50
11	CO32-	0.0	0.0	0.0	-
12	HCO3	189.1	122.0	140.3	-
13	Нийлбэр анион	220.0	139.8	163.2	
14	Нийлбэр ион	195.4	121.3	146.2	
15	Анион катионы нийлбэр	290.0	182.3	216.4	
16	pH	6.54	6.97	6.51	6.5-8.5
17	H2S				-
18	Хуурай үлдэгдэл				1000
19	Хуурай үлдэгдэл тооцоо				
20	Исэлдүүлэх чадвар	0.96	4.16	0.96	
21	Хатуулаг	3.17	2.16	2.22	7

Дүгнэлт :

Голын ус: Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд нэн цэнгэг, зөөлөн ус байна. Шинжилсэн химийн үзүүлэлтүүд нь “Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS4585:1998” стандартын шаардлага хангаж байгаа боловч “ГУЦЗАН”-тай харьцуулахад умбуур бодисын хэмжээгээр “Бохирдолтой” ангилалд хамаарч байна.

Худаг: Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, зөөлөн ус байна. Шинжилсэн химийн үзүүлэлтүүд нь “Ундны ус, Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900 : 2018 стандартын шаардлага хангаж байна.

Шүүрлийн ус: Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, зөөлөн ус байна.

5.4. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт

Хүснэгт 8. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт (газрын менежмент)

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Төлөвлөгөөний хэрэгжилтэнд зарцуулсан хөрөнгийн хэмжээ, мян.төг	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
1	Хөндөгдсөн талбайн бүртгэлийг Газарзүйн мэдээллийн систем (ГМС) дээр хөтлөх, тайлагнах	Төслийн үйл ажиллагааны хэмжээнд	Дотоод төлөвлөлтөөр	2022 онд уурхайн карьерт нэмэлт тэлэлт хийгдээгүй байна.
2	Аливаа газар хөндөх үйл ажиллагааны өмнө шимт хөрсийг тогтоосон гүнд хүртэл хуулж зөв хадгалах бүртгэл хөтлөх хаягжуулах	Төслийн үйл ажиллагааны талбайн хэмжээнд	Дотоод төлөвлөлтөөр	2022 онд уурхайн карьерт нэмэлт тэлэлт хийгдээгүй байна.
3	Шимт хөрсийг алдагдахаас хамгаалж хадгалах талбайг зөв тодорхойлох, овоолгыг зөв үүсгэхэд хяналт тавих	Төслийн үйл ажиллагааны талбайн хэмжээнд	Жилийн турш	2022 онд уурхайн карьерт нэмэлт тэлэлт хийгдээгүй байна.

Хөрсний чанар, бохирдлын мониторинг

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутаг дэвсгэрт орших Нарангийн алтны шороон ордыг ил аргаар олборлох төслийн БОМТ-ний ОХШХ-ийн хэрэгжилтийн хүрээнд хөрсний хээрийн буюу талбайн судалгааг 2022 оны 10 дүгээр сард хийж гүйцэтгэсэн. Талбайн судалгааны явцад 10 дүгээр сард 2 цэгээс хүнд металлын дээж авсан. Дээжийг авахдаа “Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS 3298:1990” стандартыг баримталсан.

5.4.1. Лабораторийн задлан шинжилгээ.

Хөрсний дээжнүүдэд хөрсний хүнд металлын хэмжээг лабораторид тодорхойллоо. Үүнд:

5.4.2. Хөрсний бохирдлын түвшин.

Хүснэгт 9. Хөрсний үзүүлэлт (хүнд металл)

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Хүнд металл мг/кг					
				Ni /никель /	Cd /кадми /	Pb /хар тугалга /	Cu /зэс/	Zn /цайр/	Cr /хром/
1	22/6567	Кемп	-	21.8	ND	8.82	8.39	81.6	ND
2	22/6568	Колонк	-	30.2	ND	15.1	30.8	99.1	10.4
3	22/6569	Авто зогсоол	-	19.2	ND	17.6	25.3	74.5	6.24
4	22/6570	Авто засвар	-	22.7	ND	25.5	32.7	101.4	13.2
Хүлцэх агууламж /MNS 5850 : 2019/				150.0	3.0	100.0	100.0	300.0	150.0
Хортой агууламж /MNS 5850 : 2019/				1000.0	10.0	500.0	500.0	600.0	400.0
Аюултай агууламж /MNS 5850 : 2019/				1800.0	20.0	1200.0	1000.0	1000.0	1500.0
Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт				/MNS 5850 : 2019/					

Никель (Ni) нь шинжилгээ хийгдсэн дээжинд 23.4 мг/кг агууламжтай байсан нь стандартад заагдсан зөвшөөрөгдөх дээд хэмжээ (150 мг/кг)- нээс бага байна.

Хар тугалга (Pb)-ын агууламжийн хувьд тухайн дээжинд 16.7 мг/кг агууламжтай байсан нь стандартад заагдсан зөвшөөрөгдөх дээд хэмжээ (100мг/кг)-нээс бага байна.

Цайр (Zn)-ын агууламжийн хувьд тухайн дээжинд 89.15 мг/кг агууламжтай байсан нь стандартад заагдсан зөвшөөрөгдөх дээд хэмжээ (300мг/кг)-нээс бага байна.

5.5. Агаар орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт
Хүснэгт 10. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт (агаарын менежмент)

#	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Төлөвлөгөөний хэрэгжилтэнд зарцуулсан хөрөнгийн хэмжээ, мян.төг	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
1	Уур амьсгалд нөлөөлөлх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр – Эрчим хүчийг хэмнэж үр ашигтай зарцуулах	Төслийн талбайд	Дотоод төлөвлөлтөөр	Уурхайн гэрэлтүүлгийг лед гэрлээр шийдсэн
2	Замын тоосжилтыг бууруулах зорилгоор усалгаа хийх боломжтой дулааны улиралд усалгааг байнга хийх	Уурхайн дотоод зам талбайн усалгаа	Дотоод төлөвлөлтөөр	Усалгааг хуваарийн дагуу тоосжилтийг дарах зорилгоор тогтмол хийж ажиллаж байна.
3	Замаас үүсэх тоосжилтыг бууруулах – хурдны хязгаарыг дагаж мөрдүүлэх (Хурдны хязгаарын тэмдэг тэмдэглэгээ байрлуулах)	Уурхайн талбайн дотоод болон талбайн гадна ашиглагдаж буй замууд	Дотоод төлөвлөлтөөр	Уурхайн талбайн дотоод болон талбайн гадна ашиглагдаж буй замуудад 20 ширхэг тэмдэг тэмдэглэгээг байрлуулсан
4	Жил бүрийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу агаар, орчин дахь тоосны хэмжээг тодорхойлж байх	Төслийн талбайд	Орчны хяналт шинжэлгээний хөтөлбөрт зардал тусгагдсан	2022оны 9 сард тоосны хэмжилтийг Үйлдвэрийн салхин дээр болон доор орчимд хийлгэсэн.



Зураг №10. Усалгаа хийж буй байдал



Зураг №11. Усалгаа хийж буй байдал

Агаарын чанар, бохирдлын мониторинг

Сүүлийн жилүүдэд Монгол оронд өсөн нэмэгдэж буй уул уурхайн үйл ажиллагаа нь их хэмжээний тоосжилт үүсэхэд хүргэж байна. Уурхайн үйл ажиллагаанаас үүсэх гол агаар бохирдуулагчид нь тоос тоосонцор, метан, хүхэрлэг хий, азотын ислүүд бөгөөд ил уурхайн хувьд уурхайн машин механизмуудын хөдөлгөөн, хүдрийг ачих, буулгах, тээвэрлэлт, ялгах зэргээс дээрх бохирдуулагчид үүсэж байдаг. Мөн түүнчлэн уурхайн машин механизмын хөдөлгүүр, бүтээгдэхүүн, хаягдал чулуулгийн ачиж буулгах үйл ажиллагаа, цахилгааны генераторууд, уурхайн тэсэлгээ зэргээс дуу шуугиан, чичиргээ үүсэж байдаг.

5.5.1. Агаарын судалгааны арга зүй

Хонгорын Орд ХХК-ийн талбайд агаарын чанарын хэмжилтийг гүйцэтгэхдээ тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан цэгүүдийг сонгож авсан ба уурхайн бүсэд үүсэж болзошгүй түгээмэл агаар бохирдуулагчдыг сонгон тодорхойлсон. Монгол улсын “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016” стандартыг мөрдлөг болгон ажилласан. Шинжилгээний болон хэмжлийн арга аргачлалын үндсийг товч авч үзье.

Хүхэрлэг хий. Төслийн талбай орчмын агаараас 2 л/мин хурдтайгаар 20 минутын турш тетрахлормеркурат натрийн уусмал (ТХМ)-аар норгосон шингээгч гуурсанд соруулахад шингээгч гуурсны шилэн бөмбөлөгийн давхаргаанд шингэсэн хүхэрлэг хийг лабораторийн нөхцөлд уусмалд шилжүүлж тэр уусмал дээрээ формальдегид, парарозанадины уусмал нэмэхэд үүссэн нэгдлийн өнгөний эрчимшлийг спектрофотометрээр хэмжин хүхэрлэг хийн хэмжээг тодорхойлно.

Азотын давхар исэл. Агаараас азотын давхар ислийг үл хатах мышьяклаг хүчлийн натрийн давс агуулсан кали иодын уусмалаар норгосон шингээгч гуурсаар 0.25 л/мин-ын хурдтайгаар 20 минутын турш соруулан авахад шингээгч гуурсны шилэн бөмбөлөгийн давхаргаанд шингээж лабораторийн нөхцөлд уусмалд шилжүүлж үүссэн нитрит ион сульфанадины хүчилтэй харилцан үйлчилж диазонэгдлийг үүсгэх бөгөөд тэр нь α -нафтиламинтай урвалд орж азобудагч бодисыг уусмалын өнгөний эрчимшлээр азотын давхар ислийн хэмжээг тодорхойлдог.

Тоос. Агаар дахь тоосны агууламжийг DustTrak 8530 гэх зөөврийн автомат багажаар тодорхойлсон бөгөөд энэ багаж нь агаар дахь нийт тоос, PM10, хэмжээтэй тоосыг хугацааны өргөн завсарт хэмжиж, хэмжилтийн хугацаанд тоосны агууламжийн хамгийн их, хамгийн бага, дундаж утгыг хэмжих боломжтой.

5.5.2. Агаар бохирдуулах бодисуудын тодорхойлолт

Хүхэрлэг хий SO₂ - Өнгөгүй, хурц үнэр, амттай, урвалд идэвхтэй ордог хий. Нүүрс, газрын тос зэрэг хүхэр агуулсан бүх төрлийн түлшний шаталт, металл боловсруулах үйл ажиллагааны дүнд үүсдэг. Орчны агаар дахь хүхэрлэг хийн агууламж нэмэгдэх нь олон талын сөрөг нөлөөлөлтэй ба өндөр агууламжтай үед гуурсан хоолойн

багтраа өвчтэй хүмүүс гадаа биеийн хүчний ажил хийж байгаа үед хүхрийн давхар исэлд их өртөмтгий байдаг. Гол нөлөө нь амьсгалын замыг нарийсгадаг бөгөөд шуухитнах, амьсгаа давчдах зэрэг шинж тэмдгүүд илэрдэг. Хүхрийн давхар исэл нь амьсгал цочроосноос найтаах, ханиах зэрэг физиологийн хариу үйлдэл үзүүлэх бөгөөд сөрөг нөлөө зогсоход уушгины үйл ажиллагаа цагийн дотор хэвийн байдалд ордог. Хүхрийн давхар ислийн архаг нөлөө нь амьсгалын замын өвчний тохиолдлыг ихэсгэх, уушгины хамгаалах механизмыг бууруулах, зүрх судасны архаг өвчнийг сэдрээдэг. Зүрх судасны өвчтэй болон уушгины архаг өвчтэй хүмүүс, түүнчлэн хүүхдүүд, өндөр настнууд архаг нөлөөнд өртөмтгий байдаг. Мөн хүчиллэг тунадас (H_2SO_4) үүсгэх зэргээр хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, дэд бүтэц зэрэг бүхий л салбарт сөргөөр нөлөөлдөг.


Азотын давхар исэл NO_2 –Азотын давхар исэл нь азот агуулсан түлшний шаталт болон өндөр температурт шаталтын бүтээгдэхүүн бөгөөд ихэвчлэн шаталтын үеийн дулаан шингээх урвалын үр дүнд үүсдэг өнгөгүй, үнэргүй хий бөгөөд агаар мандалд бор шаргал өнгөтэй болдог. Азотын давхар исэл нь уушгины эдийг цочроох ба амьсгалын замын халдварт өртөмтгий байдлыг нэмэгдүүлдэг. Азотын давхар исэл нь амьсгалын замын өвчний тохиолдлыг ихэсгэх, гуурсан хоолойн багтраа болон үрэвсэлтэй хүний мэдрэгшлийг нэмэгдүүлэх, уушгины хамгаалах механизмыг бууруулах, зүрх судасны архаг өвчнийг сэдрээх нөлөөтэй. Зүрх судасны, уушгины архаг өвчтэй хүмүүс, түүнчлэн хүүхдүүд, өндөр настнууд архаг нөлөөнд өртөмтгий байдаг.

Тоосонцор ($PM_{1.0}$, $PM_{2.5}$, $PM_{4.0}$, PM_{10} , нийт тоос TSP). Агаарын чанарын судалгаанд тоос тоосонцор гэдэг нь маш өргөн хүрээг хамарсан ойлголт бөгөөд үүсэж буй эх үүсвэр, агаар мандал дахь физик химийн урвалаас хамаараад маш жижиг буюу нано хэмжээнээс эхлээд хэдэн арван микрон хүртэлх ширхэглэгийн хэмжээтэйгээр илэрдэг.

Байгалийн эрдэс минералууд болон биологийн гаралтай тоос тоосонцор харьцангуй том ширхэглэгийн хэмжээтэйгээр агаар мандалд илэрдэг бол бүх төрлийн түлшний шаталтаас үүдэлтэй тоосонцор нь хэмжээний хувьд маш жижиг байхаас гадна хортой химийн элементүүдийг агуулж байдаг. 10 микроноос том ширхэгтэй тоос тоосонцор нь хамар ам, мөгөөрсөн хоолойд баригдаж гадагшилдаг бол 10 микроноос бага диаметртэй тоос/ PM_{10} /-ны ширхгүүд нь эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг. Тухайлбал, 2.5-10 микрон диаметр бүхий тоосны ширхгүүд нь уушгины мөгөөрсөн хоолой болон хялгасан судлуудад хуримтлагдах, харин 2.5 микроноос бага диаметртэй ширхгүүд нь уушгины цулцангуудад шигдэх аюултай байдаг.



Зураг №12. Агаар мандал дахь тоосонцруудын харьцангуй агууламж



Зураг №13. Агаар дахь тоосонцорын ширхгийн хэмжээнээсээ хамааран хүний амьсгалын эрхтнүүдээр шүүгдэж хуримтлагдах хэмжээ

Тоосонцор хэмжигч багаж: Судалгаанд ашиглагдсан тоос хэмжигч багажууд нь АНУ-ын TS’ корпорацийн бүтээгдэхүүн бөгөөд DustTruck 8530 загварын хувьд агаар дахь тоос тоосонцрыг ширхэглэгийн хэмжээнээс нь хамааруулан сонгомол хэлбэрээр тодорхойлдог бол DustTrak 8530 загвар янз бүрийн ширхэглэгийн хэмжээтэй тоос тоосонцрын масс агууламжийг нэгэн зэрэг тодорхойлдог.



Зураг №14. Агаар дахь тоос хэмжигч багаж

Уг багажийн ажиллах зарчим нь агаарын сорьцыг сорох төхөөрөмжийн тусламжтайгаар соруулан оптик системээр нэвтрүүлэхэд лазер гэрлийн сарнил тухайн агшинд оптик систем дундуур өнгөрч буй агаар дахь тоосны агууламжтай шууд хамааралтай байдагт үндэслэдэг. Харин сарнисан гэрлийн эрчимшил нь тоос тоосонцрын ширхэглэгийн тухай мэдээллийг өгдөг.

Хий төлөвт бохирдуулагчдын сорьц авах, хэмжилт хийх багаж төхөөрөмжүүд:


Орчны агаар дахь хүхэрлэг хий, азотын давхар ислийн агууламжийг харгалзан MNS 17.2.5.11, MNS 17.2.5.12 аргачлалуудаар тодорхойлсон бөгөөд агаараас хийн сорьц авахад АНУ-н SKC компанийн A'rCheck 2000 багаж, лабораторийн химийн шинжилгээнд гэрэл зүйн нягтыг хэмжихэд АНУ-н Thermo F'sher компанийн Genesys 20 спектрофотометрийг тус тус ашигласан.

5.5.3. Агаарын чанарын төлөв байдал.

Агаарын хяналт шинжилгээний ажлын хүрээнд эх үүсвэрүүдийг нарийвчлан тогтоож, төслийн үйл ажиллагаа тогтмол явагддаг газруудад 5 мониторингийн цэгт азотын давхар исэл, хүхэрлэг хий, том ширхэглэгт тоосонцор гэсэн үзүүлэлтүүдээр 2022 оны 9 дүгээр сарын 10-нд хийж гүйцэтгэсэн байна. Нарийн ширхэглэгт тоосонцрын агууламжийг тогтооход Dusttrak Pro 8530, түгээмэл бохирдуулагч бодисуудын судалгаанд агаар сорох насос, агаарын даралт чийг, температур хэмжигч гар багаж зэрэг багаж төхөөрөмжүүдийг ашигласан байна.

5.5.4. Азотын давхар исэл /NO₂/-ийн агууламж

Төслийн талбай дах азотын давхар ислийг үүсгэдэг гол эх үүсвэрүүдэд төслийн талбайн орчинд тээвэрлэлтэнд ашиглагдаж байгаа автомашинууд хамаарна.




Зураг №15. Азотын давхар исэлийн хэмжээ

Шинжилгээний дүнгээс харахад агаар дахь азотын давхар исэлийн хэмжээ стандартаас давсан үзүүлэлтгүй хэдий ч өнгөрсөн зургаан сарын үр дүнтэй харьцуулахад бага зэрэг өссөн үзүүлэлттэй байна.

5.5.5. Хүхэрлэг хий /SO₂/-ын агууламж:


Агаарын чанарын судалгаа хийсэн бүх цэгүүд нь хүхэрлэг хийн 6 болон 9 дүгээр саруудын утга хүлцэх хэмжээнээс давсан тохиолдол ажиглагдаагүй.



Зураг №16. Хүхэрлэг хийн хэмжээ

5.5.6. Том ширхэглэгт тоосонцор /PM₁₀/-ын агууламж

Хонгорын орд ХХК-ийн уурхай орчимд олборлолтын үйл ажиллагаатай холбоотойгоор тоос, тоосонцор газрын хөрснөөс дэгддэг бөгөөд тоосонд маш олон төрлийн диаметртэй эгэл хэсгүүд зонхилдог. Энд 10 микрометр диаметртэй тоосонцрыг сонгож судалгааг хийсэн байна.



Зураг №17. Тоосонцорын хэмжээ

Хэмжилтийн үр дүнгээс харахад тоосонцрын хэмжээ 6-р сард хийгдсэн хэмжилтийн утгаас ил уурхайн орчим хэмжсэн хэмжилтийн утга хамгийн өндөр буюу “Агаарын чанарын стандарт MNS 4585:2016”- тай ижил үзүүлэлттэй буюу $0.5\text{мг}/\text{м}^3$ байна. Бусад үзүүлэлтийн хувьд стандартаас давсан үзүүлэлт байхгүй байна.

ЗУРГАА. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Хүснэгт 11. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилт

№	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Нөхөн сэргээлтийн хамрах хүрээ	Төлөвлөгөөний хэрэгжилтэнд зарцуулсан хөрөнгийн хэмжээ, мян.төг	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
1	Биологийн нөхөн сэргээлт	2022 оны 08 сарын 22 нд Хараа-Ерөө голын сав газрын захиргаатай усны гэрээ байгуулж, уурхайн үйл ажиллагаа оройтож эхэлсэн учир шинээр блок нээгээгүй, нөхөн сэргээлтийн ажил хийгдээгүй болно.		
2	Техникийн нөхөн сэргээлт			
3	Хаалтын төлөвлөгөө	2023 онд уурхайн хаалтын төлөвлөгөөг журмын дагуу боловсруулж, батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллана.		

ДОЛОО. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ, ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Хүснэгт 12. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

№	Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ	Дүйцүүлэн хамгааллын хамрах хүрээ	Төлөвлөгөөний хэрэгжилтэнд зарцуулсан хөрөнгийн хэмжээ, мян.төг	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
1	Хүний үйл ажиллагааны нөлөөгөөр эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлт хийх	Уурхай болон тосгон	50,000.0	Монгол улсын Засгийн газрын 2020-2024 үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 5.1.8, Нөхөн сэргээлт-2024 арга хэмжээтэй уялдуулан аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас ирүүлсэн 5 га талбайн 3 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн ба үлдсэн талбайд дараа оны 2-р улиралд техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэн БОАЖСайдын 2015 оны тушаалын дагуу аймаг, сумын хамтарсан комисст хүлээлгэн өгнө (Зураг №15, 16).
2	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих ажлыг зохион байгуулах	Уурхай болон тосгон	5,000.0	2022 онд тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд орон нутагт 5,000,000 төгрөгийн санхүүлжилтийг шийдвэрлэсэн (Зураг №17, 18, 19, 20).



Зураг №18. Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай



ураг №19. Нөхөн сэргээлт хийсэн талбай



Зураг №20. Нөхөн сэргээлт хийсэн талбайн солбилцол



Зураг №21. Тэрбум мод үндэсний хөдөлгөөн



Зураг №22. Тэрбум мод үндэсний хөдөлгөөн



Зураг №23. Тэрбум мод үндэсний хөдөлгөөн

Хэвлэсэн огноо: 2022/10/28



Депозит дансны хуулга - Байгууллага

Дансны нэр: ХОНГОРЫН ОРД
 Дансны дугаар: MN030030003022063190
 Мөнгөний нэгж: MNT

Эхлэх огноо: 2022.10.27
 Дуусах огноо: 2022.10.28
Эхний үлдэгдэл: 22,019,800.35

Гүйлгээний огноо	Теллер	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл	Харьцсан данс	Банк хоорондын данс	Гүйлгээний утга	Бансны код	Бансны нэр	Ханш
10/27/2022 4:11:17 PM	2	0.00	5,000,000.00	17,019,800.35	100130855408	100130855408 EB -Модны суулгацны үнэ (2577453)		90	90 - ТӨРӨЙН САН	1.00
10/27/2022 4:11:17 PM	2	0.00	200.00	17,019,600.35	100130855408	НБ БАНК ХООРОНДЫН ГҮЙЛГЭЭНИЙ ЗАМЛТЭГ(200.00MNT) /447230				1.00
10/27/2022 4:18:33 PM	2	0.00	11,998,133.20	5,021,467.15	100130000944	100130000944 EB -Усны ашигласны төлбөр (2577453)		90	90 - ТӨРӨЙН САН	1.00
10/27/2022 4:18:33 PM	2	0.00	200.00	5,021,267.15	100130000944	НБ БАНК ХООРОНДЫН ГҮЙЛГЭЭНИЙ ЗАМЛТЭГ(200.00MNT) /447230				1.00
Дүн		0.00	16,998,533.20				Эцсийн үлдэгдэл:			5,021,267.15

Зураг №24. Модны суулгацны төлбөр шилжүүлсэн баримт

НАЙМ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

Хүснэгт 13. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

№	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговорын хамрах хүрээ	Төлөвлөгөөний хэрэгжилтэнд зарцуулсан хөрөнгийн хэмжээ, мян.төг	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
1	2022 онд Хонгорын Орд ХХК-ийн ашиглалтын талбайтай давхцалтай айл өрх байхгүй учир нүүлгэн шилжүүлэх ажил хийгдэхгүй болно.			

ЕС. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Хүснэгт 14. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт

№	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ	Түүх соёлын өвийн хамрах хүрээ	Төлөвлөгөөний хэрэгжилтэнд зарцуулсан хөрөнгийн хэмжээ, мян.төг	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
1	Археологийн дурсгал	Уурхайн лицензийн талбай	10,000.0	2021 онд археологи, палентеологийн судалгааны ажлыг лицензийн талбайн хэмжээнд хийлгэсэн. Уурхай орчимд түүх соёлын болон палентеологийн дурсгал бүртгэгдээгүй. Археологи, палентеологийн судалгааны тайланг тайланд хавсаргасан болно.
2	Палентеологийн дурсгал			

АРАВ. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Хүснэгт 15. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт

№	Осол эрсдэлийн менежментийн арга хэмжээ	Хамрах хүрээ	Төлөвлөгөөний хэрэгжилтэнд зарцуулсан хөрөнгийн хэмжээ, мян.төг	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
1	Цаг агаарын улирлын, 7 хоногийн, сарын, өдөр тутмын мэдээг ажилчдад танилцуулах	Уурхайн бүх байгууламж, ажилчид, техник хэрэгсэл	Дотоод төлөвлөлтөөр	Цаг уурын гамшигт үзэгдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 7 хоног бүр ажилчдад цаг агаарын мэдээг танилцуулж ажилласан. (Зураг №25).
2	Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан, албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах	Хонгорын Орд ХХК-ийн бүх ажилчид	Дотоод төлөвлөлтөөр	Галын аюулгүй байдлын заавар зөвлөмж мэдээллээр ажилчдыг бүрэн хамруулдаг. (Зураг №25).
3	Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, галын хор зэргийг тогтсон стандартын дагуу байрлуулж бэлэн байдлыг тогтмол хангаж ажиллах	Хонгорын Орд ХХК	Дотоод төлөвлөлтөөр	Гамшгаас хамгаалах тухай хуулийн сургалт семинарт ажилчдыг бүрэн хамруулсан. (Зураг №25).
4	Болзошгүй ослын үед авах арга хэмжээг төслийн нийт албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах	Нийт ажилчид	Дотоод төлөвлөлтөөр	2022 онд бүх ажилчдыг хамруулан 4 удаа сургалт хийсэн. (Зураг №25).
5	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэнд хяналт тавих	Нийт ажилчид	Дотоод төлөвлөлтөөр	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм журмын хэрэгжилтийг ханган ажилласан. (Зураг №25).



Зураг №25. Ажилчдад хөдөлмөр хамгааллын сургалт орж буй байдал

АРВАН НЭГ. ХОГ ХАЯГДАЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Хүснэгт 16. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт

№	Хог хаягдлын менежментийн арга хэмжээ	Хамрах хүрээ	Төлөвлөгөөний хэрэгжилтэнд зарцуулсан хөрөнгийн хэмжээ, мян.төг	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
1	Төслөөс гарч байгаа хаягдлыг бууруулах, дахин ашиглах, боловсруулах чиг хандлагыг үргэлжлүүлэн ажиллах	Уурхайн талбай	Дотоод төлөвлөлтөөр	Энгийн буюу ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж хоёрдогч түүхий эд авах Ногоон газар трейдинг ХХК-тай гэрээ хийж хамтарч ажилласан. (Зураг №29).
2	Хог хаягдлын цэгийг шинэчлэн сайжруулах /Ёроол хэсгийг бетондож, хануудыг блокоор өрж барьж байгуулах/	Хог гаргаж байгаа харьяа хэлтэсүүд	Дотоод төлөвлөлтөөр	Хогийн цэгийг хөрс бохирдуулахаас хамгаалж ёроолыг бүрэн бетондсон.
3	Бүх нийтийн цэвэрлэгээ тогмол хийх	Бүх ажилчид	Дотоод төлөвлөлтөөр	Уурхайн бүх ажилчид намар нийтийн цэвэрлэгээ хийж ажилласан. (Зураг №26, 27).
4	Хог хаягдал үүсгэгч болон эрх бүхий иргэн, ААН, байгууллага нь батлагдсан маягт болон “эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт”-ын дагуу хог хаягдлын тоо бүртгэлээ тухай бүр хөтөлж, тогтоосон хугацаанд тайлангаа сум, орон нутагт хүргүүлэх	Хог гаргаж байгаа харьяа хэлтэсүүд	Дотоод төлөвлөлтөөр	Уурхайгаас гарч буй хог хаягдлын бүртгэл жагсаалт хөтөлж, сум орон нутагт тайлангаа хүргүүлсэн.
5	Хаягдал тос хадгалах талбайг томруулах, зориулалтын хадгалах савнуудыг олноор байрлуулах, дахин боловсруулах газартай гэрээ байгуулан хамтарч ажиллах	Хог гаргаж байгаа харьяа хэлтэсүүд	Дотоод төлөвлөлтөөр	Засварын талбайгаас гарах хаягдал тосыг 200л-ийн 5 төмөр саванд хуримтлуулан дахин боловсруулах Алтан Оршихуй Групп ХХК-ийн

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт байрлах “Нарангийн аманд байрлах алтны шоон ордыг ил аргаар олборлох төсөл”-ийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

				Ахуй мандал давхарын үйлдвэрт гэрээгээр нийлүүлсэн. (Зураг №29).
6	Аюултай хог хаягдлыг тээвэрлэх ажиллагааг журамлаж, бусад төрлийн хог хаягдалтай холихгүй, тусад нь тээвэрлэж, тусгай зориулалтын газар хадгалах, устгах	Хог гаргаж байгаа харьяа хэлтэсүүд	Дотоод төлөвлөлтөөр	Аюултай хог хаягдлыг тусад нь ангилан ялгадаг (Зураг №30).



Зураг №26. Бүх нийтийн цэвэрлэгээ




Зураг №27. Бүх нийтийн цэвэрлэгээ



Зураг №28. Бохирын цооног



Зураг №29. Энгийн хог хаягдал ангилан ялгах сав



Зураг №30. Хаягдал тос түр хадгалах сав

АРВАН ХОЁР. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

Хүснэгт 17. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилт

№	Орчны хяналт шинжилгээний арга хэмжээ	Хамрах хүрээ	Төлөвлөгөөний хэрэгжилтэнд зарцуулсан хөрөнгийн хэмжээ, мян.төг	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
АГААРЫН ЧАНАР				
1	Тоосонцорын /TSP, PM10, PM2.5/ агууламж	Уурхайн карьер, ажилчдын тосгон	Дотоод төлөвлөлтөөр	Өөрсдийн агаарын чанарын хэмжилтийн багаж ашиглан тоосны хэмжилтийг тогтмол хийж ажиллаж байна. Тайлангийн “Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө”-ний агаар, орчны хамгаалах төлөвлөгөөний хэсэгт дэлгэрэнгүй орууллаа.
ХӨРСНИЙ ЧАНАР				
2	Хөрсний агрохимийн үндсэн үзүүлэлт	Уурхайн карьер орчим, тосгон орчим	Дотоод төлөвлөлтөөр	Уурхайн карьер болон хогийн цэг орчмоос дээж авч “Инженер геофизи ХХК”-ийн итгэмжлэгдсэн лабораторит шинжилгээ хийлгэсэн. Шинжилгээний хариуг тайлангийн “Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт”-ийн Хөрсөн бүрхэвчийг хамгаалах арга хэмжээ хэсэгт дэлгэрэнгүй оруулсан. Шинжилгээний хариуг тайлангийн хавсралт хэсэгт оруулсан болно.
3	Хүнд металлын агууламж	Хогийн цэг, Авто засвар		
УРГАМЛАН БҮРХЭВЧ				
4	Орчны тохижилт ногоон байгууламжын хяналт шинжилгээ	Уурхайн тосгоны орчимд	Дотоод төлөвлөлтөөр	Уурхайн бүсэд орчны тохижилт, ногоон байгууламжийн тоо толгойг нэмэгдүүлэх зорилгоор хайлаас, сухай зэрэг модлог ургамлыг тарьж ургуулах, цэцгийн мандал байгуулах зэрэг ажлуудыг зохион байгуулсан. Тайлангийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэсэгт дэлгэрэнгүй оруулсан болно.
УСНЫ ЧАНАР				

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт байрлах “Нарангийн аманд байрлах алтны шоон ордыг ил аргаар олборлох төсөл”-ийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

